

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/75/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Булган аймаг 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: <a href="mailto:Erdeneb@audit.gov.mn">Erdeneb@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: <a href="mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn">Enkhtsoodolj@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: <a href="mailto:enkhturb@audit.gov.mn">enkhturb@audit.gov.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....

  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....

5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс:7034-2580  
E-mail:bulgan@audit.gov.mn

2023.02.14 № 55  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

Г БУЛГАН АЙМГИЙН БҮРЭГХАНГАЙ Г  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН Г  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Г  
Ц.ЛХАГВАСҮРЭН ТАНАА Г

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын батлагдсан төсвөөс зөвлөн туслах үйлчилгээг анхан шатны баримтын бүрдэлгүй 1,100.0 мянган төгрөг, бараа материалын тооллогоор 208 кг махны 1,868.0 мянган төгрөг, зориулалт бус зарцуулалт хийсэн 2,050.0 мянган төгрөг, хүүхдийн хоолны зардалд тендер шалгаруулаагүй шууд худалдан авалт хийсэн 119,099.6 мянган төгрөг, үр дүнгийн урамшуулалттай холбоотой 1,388.0 мянган төгрөг, түрээсийн орлого 460.0 мянган төгрөг, тушаал шийдвэргүйгээр цалин тооцож олгосон 836.1 мянган төгрөг, шатахууны зардлаас илүү зарцуулсан 119.7 мянган төгрөг, нийт 126,921.4 мянган төгрөгийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд сонгосон материаллаг байдлын дүнгээс илүү илэрхийлэгдэж санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

006020247

Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 онд шилэн дансны 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дах "Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй.

#### **Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

#### **Бусад асуудлын хэсэг**

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 2022 онд 7 зорилтын хүрээнд 105 ажил төлөвлөж гүйцэтгэлийн биелэлт 83.6 хувьтай дүгнэгджээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

#### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>95,260,657.84</b>	<b>122,426,173.69</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	42,923,239.45
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	42,923,239.45
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	42,923,239.45
31211	Төрийн сангийн харилцах	-	42,923,239.45
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	71,134,557.84	79,502,934.24
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	71,134,557.84	79,502,934.24
35410	Бичиг хэргийн материал	2,244,300.00	2,736,440.00
35420	Аж ахуйн материал	60,943,439.24	62,770,939.24
35460	Хүнсний материал	6,372,168.60	11,070,705.00
35470	Бусад хангамжийн материал	1,574,650.00	2,924,850.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,858,736,750.48</b>	<b>2,235,262,557.40</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,858,736,750.48	2,235,262,557.40
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,812,429,201.53	2,189,896,828.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,804,978,942.60	2,151,278,942.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(153,046,861.29)	(207,558,500.01)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	11,000,000.00	11,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(2,138,888.85)	(2,872,222.17)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	107,585,770.05	202,961,856.45
39206	Хуримтлагдсан элэгдэл	(43,480,549.73)	(60,273,020.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	117,049,551.96	135,215,824.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	(41,571,098.73)	(53,577,417.58)
39217	Ном	12,052,335.52	13,721,365.52
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	46,307,548.95	45,365,728.47
39303	Бусад биет бус хөрөнгө	48,458,010.39	48,458,010.39
39304	Хуримтлагдсан элэгдэл	(2,150,461.44)	(3,092,281.92)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,953,997,408.32</b>	<b>2,357,688,731.09</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>11,789,613.78</b>	<b>11,789,613.78</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	11,789,613.78	11,789,613.78
<b>413</b>	<b>Өглөг</b>	11,789,613.78	11,789,613.78
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	11,789,613.78	11,789,613.78
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,672,689,990.10</b>	<b>2,345,899,117.31</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,672,689,990.10	2,345,899,117.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	269,517,804.44
51101	Өмч: - төрийн		269,517,804.44
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	659,643,673.20	1,063,334,995.97
51210	Өмнөх үеийн үр дүн	659,643,673.20	659,643,673.20
51220	Тайлант үеийн үр дүн	-	403,691,322.77
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,013,046,316.90	1,013,046,316.90
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,684,479,603.88</b>	<b>2,357,688,731.09</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

#### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>888,468,329.20</b>	<b>1,510,508,788.90</b>

<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>23,904,656.09</b>	<b>411,025,288.90</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,724,656.09	378,930,488.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,724,656.09	378,930,488.90
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,724,656.09	378,930,488.90
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	21,180,000.00	32,094,800.00
122001	Хандив тусламж /дотоод/	21,180,000.00	32,094,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>864,563,673.11</b>	<b>1,099,483,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	656,758,400.00	885,975,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	885,975,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	178,440,320.11	213,508,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	178,440,320.11	213,508,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>913,444,159.17</b>	<b>1,106,817,466.13</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>913,444,159.17</b>	<b>1,106,817,466.13</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	862,495,178.44	1,060,818,517.49
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	491,836,482.60	622,416,455.29
210101	Үндсэн цалин	310,218,245.44	478,994,575.29
210102	Нэмэгдэл	138,251,930.82	118,987,052.00
210104	Урамшуулал	43,366,306.34	24,434,828.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	62,812,389.45	78,002,836.62
210201	Тэтгэврийн даатгал	43,939,657.49	52,843,379.43
210202	Тэтгэмжийн даатгал	4,831,372.62	6,439,293.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,773,553.76	4,955,910.99
210204	Ажилгүйдлийн даатгал	976,134.69	1,251,504.68
210205	Эрүүл мэндийн даатгал	9,291,670.89	12,512,748.10
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	177,281,674.11	181,783,349.00
210301	Гэрэл, цахилгаан	5,801,796.00	8,018,048.00
210302	Түлш, халаалт	171,139,324.11	172,639,328.00
210303	Цэвэр, бохир ус	340,554.00	1,125,973.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,510,810.00	1,388,400.00
210401	Бичиг хэрэг	2,611,750.00	130,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,981,510.00	77,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,287,050.00	1,180,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	29,122,973.40	60,321,894.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	978,250.00	60,000.00
210502	Хоол, хүнс	28,144,723.40	60,261,894.60
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,511,350.00	4,350,300.00
210604	Урсгал засвар	9,511,350.00	4,350,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,293,200.00	5,091,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,293,200.00	1,580,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	3,511,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	77,845,298.88	107,463,481.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	14,859,651.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	7,618,249.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,445,298.88	84,985,581.98
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	50,948,980.73	45,998,948.64
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,967,850.00	45,721,990.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,586,050.00	45,721,990.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	36,975,727.73	276,958.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,975,727.73	276,958.64

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(24,975,829.97)	403,691,322.77
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(32,195,779.26)	403,691,322.77

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

#### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>885,743,673.11</b>	<b>1,099,483,500.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>864,563,673.11</b>	<b>1,099,483,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	656,758,400.00	885,975,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	885,975,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	178,440,320.11	213,508,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	178,440,320.11	213,508,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>861,329,492.11</b>	<b>1,027,525,260.55</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>861,329,492.11</b>	<b>1,027,525,260.55</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>807,947,711.38</b>	<b>976,220,636.91</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	479,859,970.08	621,001,115.51
210101	Үндсэн цалин	296,505,785.06	472,225,232.58
210102	Нэмэгдэл	140,190,037.95	124,341,055.21
210104	Урамшуулал	43,164,147.07	24,434,827.72
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	62,999,288.19	78,441,997.40
210201	Тэтгэврийн даатгал	44,126,556.23	53,131,735.42
210202	Тэтгэмжийн даатгал	4,831,372.62	6,426,077.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,808,833.76	5,149,006.62
210204	Ажилгүйдлийн даатгал	940,854.69	1,248,861.48
210205	Эрүүл мэндийн даатгал	9,291,670.89	12,486,316.08
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	177,703,939.11	182,759,528.00
210301	Гэрэл, цахилгаан	5,801,796.00	8,994,227.00
210302	Түлш, халаалт	171,139,324.11	172,639,328.00
210303	Цэвэр, бохир ус	762,819.00	1,125,973.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	29,234,354.00	59,059,956.00
210502	Хоол, хүнс	27,402,104.00	59,059,956.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	34,519,200.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	10,834,200.00	1,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,265,800.00	6,196,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,265,800.00	1,580,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,616,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	12,454,400.00	27,261,240.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	19,398,490.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,954,400.00	7,862,750.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>53,381,780.73</b>	<b>51,304,623.64</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	16,400,650.00	51,027,665.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,018,850.00	51,027,665.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	36,975,727.73	276,958.64

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,975,727.73	276,958.64
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>24,414,181.00</b>	<b>71,958,239.45</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>14,682,000.00</b>	<b>29,035,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>14,682,000.00</b>	<b>29,035,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	14,682,000.00	29,035,000.00
222001	Тоног төхөөрөмж	6,150,500.00	26,599,000.00
223001	Бусад хөрөнгө	8,531,500.00	2,436,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(14,682,000.00)</b>	<b>(29,035,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	9,732,181.00	42,923,239.45
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	42,923,239.45

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

##### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	269,517,804.44	1,013,046,316.90	659,643,673.20	1,942,207,794.54
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	269,517,804.44	1,013,046,316.90	659,643,673.20	1,942,207,794.54
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	403,691,322.77	403,691,322.77
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	269,517,804.44	1,013,046,316.90	1,063,334,995.97	2,345,899,117.31

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

##### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	813832700.00	798222992.38
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	813832700.00	796447992.38
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	794339400.00	780047342.38
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	487073800.00	479859970.08
210101	Үндсэн цалин	319762300.00	296505785.06
210102	Нэмэгдэл	137689600.00	140190037.95
210104	Урамшуулал	29621900.00	43164147.07
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	65525000.00	62999288.19
210201	Тэтгэврийн даатгал	46042000.00	44126556.23
210202	Тэтгэмжийн даатгал	4824800.00	4831372.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	3942600.00	3808833.76
210204	Ажилгүйдлийн даатгал	974200.00	940854.69
210205	Эрүүл мэндийн даатгал	9741400.00	9291670.89
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	178574300.00	176941120.11
210301	Гэрэл, цахилгаан	5109000.00	5801796.00

210302	Түлш, халаалт	172536400.00	171139324.11
210303	Цэвэр, бохир ус	928900.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4330600.00</b>	<b>4064810.00</b>
210401	Бичиг хэрэг	281000.00	281000.00
210402	Тээвэр, шатахуун	1618400.00	1615110.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	405,300.00	200,000.00
210404	Ном, хэвлэл	224,900.00	168,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	843,600.00	843,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	957,400.00	956,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>54,505,100.00</b>	<b>29,234,354.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	480,800.00	471,250.00
210502	Хоол, хүнс	52,663,200.00	27,402,104.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,361,100.00	1,361,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>14,159,200.00</b>
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,159,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>281,000.00</b>	<b>281,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	281,000.00	281,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>160,200.00</b>	<b>53,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	160,200.00	53,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,389,400.00</b>	<b>12,454,400.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,389,400.00	10,954,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19,493,300.00</b>	<b>16,400,650.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>19,493,300.00</b>	<b>16,400,650.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,078,300.00	16,018,850.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	415,000.00	381,800.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>(813,832,700.00)</b>	<b>835,198,720.11</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>(633,758,400.00)</b>	<b>656,758,400.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	(633,758,400.00)	656,758,400.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>(180,074,300.00)</b>	<b>178,440,320.11</b>
132001	Орон нутгийн төсвөөс	(180,074,300.00)	178,440,320.11

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	/ төгрөгөөр / Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>29,359,550.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>16,452,550.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	16,452,550.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	564,950.00
210401	Бичиг хэрэг	-	184,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	379,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	9,675,000.00
210604	Урсгал засвар	-	9,675,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	6,212,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	6,212,600.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>5,403.00</b>

213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,403.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>12,907,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	12,907,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	4,715,500.00
223001	Бусад хөрөнгө	-	8,191,500.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>-</b>	<b>29,364,953.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	<b>29,364,953.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,364,953.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн нь “Сурагчдад зөв хандлагыг төлөвшүүлж, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэн, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлнэ” гэсэн эрхэм зорилго болгон ажиллаж байна.

Бүрэгхангай сургууль нь 4 зорилготыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Сурагчдын дүрэм мөрдөн хэвшүүлэх
- Сурагчдыг хандлагын сургалтад хамруулах
- Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх
- Хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангах

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол улсын үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, тогтоол шийдвэр, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулж, хэрэгжилт нь үр нөлөөтэй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ. Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургууль нь дотоод аудит, аудиторгүй дотоод хяналтын бүрэлдэхүүнтэй тус хяналт нь улирлаар үйл ажиллагааны хяналт шалгалтыг хийж байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 403.4 сая төгрөгөөр буюу 21 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	42,923,239.45	42,923,239.45
Авлага	24,126,100	0	24,126,100
Бараа материал	71,134,557.84	79,502,934.24	(8,368,376.40)
Үндсэн хөрөнгө	1,858,736,750.48	2,235,262,557.40	(376,525,806.92)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,953,997,408.32</b>	<b>2,357,688,731.09</b>	<b>(403,691,322.77)</b>
Өр төлбөр	11,789,613.78	11,789,613.78	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	269,517,804.44	269,517,804.44	0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,953,997,408.32</b>	<b>2,357,688,731.09</b>	<b>(403,691,322.77)</b>

Дээрх хүснэгтээс харахад, 2022 он өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн дансны талаар товч тайлбарлан бичнэ.

Үндсэн хөрөнгийн дүн өссөн нь Ерөнхий боловсролын сургуулиудад МУ-ын БШУ-ны Сайдын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/494 тушаалын дагуу цахим анги тохижуулах "Хүүхдэд ээлтэй орчин" бүрдүүлэхэд Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургуульд цахим ангийн тоног төхөөрөмж, сандал 40.05 сая төгрөгийн худалдан авалт хийж, дотуур байрны барилгын их засвар хийх хандиваар Монполиммент компаниас 150.0 сая Улсын төсвөөс 196.3 сая нийт 396.6 сая төгрөгөөр хөрөнгийн хэмжээ өмнөх оноос нэмэгдсэн шалтгаанаар өөрчлөлт гарсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

МУ-ын БШУ-ны Сайдын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/494 тушаалын дагуу цахим анги тохижуулах "Хүүхдэд ээлтэй орчин" Тендер зарлаж 40.05 сая төгрөгөөр тоног төхөөрөмж цахим дэлгүүрээс худалдан авалт хийжээ.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 901.9 сая нийт зарлагыг 901.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 901.9 сая төгрөгөөр өгсөн боловч тус саналаас зардлыг 16.0 сая төгрөгөөр бууруулж, 885.9 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй төлөвлөсөн боловч үндсэн хөрөнгө бэлтгэх саналыг хасаж баталсан шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 16.0 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрийн 38 арга хэмжээг санхүүжүүлэхээр 885.9 сая төгрөгийг улсын төсвөөс баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 885.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 213.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогоос 0.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1099.4 сая төгрөг буюу 96 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 42.9 сая, 0.2 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

**Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Байр ашиглалтын үйлчилгээ /80226/	3715000	3715000	0	100
2	Сургалт семинар /80312/	1857500	1872782	31718	98.3
3	ЭМД шимтгэл /80823/	4272300	4268400	3900	99.9
4	Үдийн цай хөтөлбөр /81801/	82061900	74369840.4	7692050.6	91
5	Дотуур байрны үйлчилгээ /81806/	93735800	82762085.28	10973714.72	88.3
6	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин /81816/	41960000	41542620	417680	99.1
7	Боловсролын байгууллагын багш /81823/	8358800	8358706	94	99.99
8	Боловсрол стандарт сургалт /81834/	924400800	869759894.42	54640905.58	94.1
9	Сургалтын хэвийн үйл ажиллагаа /81835/	118968100	114448000.15	4520099.85	96.3
10	Гүнзгийрүүлсэн төрөлжсөн /81844/	650000	650000	0	100
11	Сурах бичгийн түрээс /818848/	1971800	913400	1058400	13.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны санхүүгийн тайлангаар нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

2022 онд Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургууль дээр төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй байна.

**4. АУДИТЫН ТАЙЛАН**

**4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг Аудитын менежер Ж.Энхцоодол, Дарга, Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 1 хувиар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны бусад 11.1 сая төгрөгөөс 70 хувиар буюу 7.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь Өмнөх 2021 онд сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаа цар тахалтай холбоотойгоор хэвийн бус ажиллаж цахилгаан эрчим хүч, дулааны зардал хэмнэгдсэн. Тайлант онд хичээл сургалтын үйл ажиллагаа хэвийн жигд ажиллаж байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 онд шилэн дансны 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дахь "Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй.

*Шийдвэрлэсэн нь:* Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төсвийн тухай хууль, Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллыг сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал, ЗГ-ын 2011 оны 311 тогтоол зэрэг хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомж, Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбогдох заалттай нийцээгүй тул албан шаардлага бичиж бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд завсарын аудит хийж аудитаар төлбөрийн акт 4, албан шаардлага 4, зөвлөмж 5, залруулага 3 алдаа зөрчил илэрсэн байна.

Өмнөх онд 6.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 522.4 сая төгрөгийн албан шаардлага, 1.6 сая төгрөгийн зөвлөмжийг хүргүүлж биелэлтийг бүрэн хангаж ажиллажээ.

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд завсрын аудит хийж 144.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлжээ.

Үүнд: 4,264.1 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт, 121,149.6 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 1,519.9 мянган төгрөгийн 1 хариуцлага тооцох албан шаардлага, 1,388.02 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж, 16,039.9 мянган төгрөгийн 3 алдааг залруулга хийсэн байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

*Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.*

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн Б/15 албан тоотоор ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	6.3	1	6.3	100
Албан шаардлага	4	522.4	4	522.4	100
Зөвлөмж	2	1.5	2	1.5	100
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>530.2</b>	<b>7</b>	<b>530.2</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хагас бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогыг чанартай хийх, эд хөрөнгийг бусад байгууллагад эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр шилжүүлэхгүй байх, зориулалт бус зарцуулалт хийхгүй байх, хамаарал бүхий этгээдээс худалдан авалт хийхгүй байх, дотоод хяналтыг сайжруулах, хууль журмын дагуу тендер зарлаж худалдан авалт хийх, бүтэц орон тоо нь батлагдаагүй ажилтан ажиллуулахгүй байх, шалгуур үзүүлэлт хангасан албан хаагчид урамшуулал олгох, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж ажиллах шаардлагатай байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар явцад 16.1 сая төгрөгийн 3 алдааг залруулсан алдаа<sup>1</sup> зөрчилд бүртгэлээ. Үүнд:

1.Боловсролын ерөнхий газраас 2022 онд шилжиж ирсэн үндсэн хөрөнгөөс хүүхдийн цэцэрлэгт 3,300.0 мянган төгрөгийн хоолны тогоог, 647.0 мянган төгрөгийн үнэтэй зурагтыг сумын ИТХ-д эрх бүхий байгууллагын шийдвэргүй шилжүүлсэн, байгууллагын хөрөнгийг дутагдуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-д "хуульд өөрөөр заагаагүй бол төрийн

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ." НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д заасан ч тус хөрөнгийг данснаас хасаагүй цаад байгууллага баланст бүртгээгүй тул буцааж залрууллаа.

2. Бичиг хэргийн зардлын дансны зарцуулалтын журналын бичилтийг буруу данс руу хаасан нь санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байсныг залруулах бичилт хийсэн.

3. Цалингийн зардлаас ХХОАТ, НДШ-ийн өглөг дансанд давхар бичилт хийгээгүй шууд зардалд бичсэн нь санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангаагүй байсныг залруулах бичилт хийж ажилласан.

## **5.1 Төлбөрийн акт**

1. Байгууллагын данснаас Ганчимэгт зөвлөн туслах гэх гүйлгээний утгатай 1.1 сая төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно."

2. Санхүүгийн тайлангийн явцын аудитаар бараа материалын тооллого хийхэд 9.5 мянган төгрөгийн 136 кг, 8.0 мянган төгрөгийн 72 кг нийт 1.8 сая төгрөгийн мах дутагдуулсан нь НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ." МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.3.7-д заасан заалтын дагуу төлбөрийн акт тогтоох.

3. Дотуур байрны түрээсийн байрны түрээсийн орлого 460.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн нь Санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй нь Төсвийн тухай хуулийн 41.2.1-д "хуулийн дагуу улс орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"

4. Сургуулийн захирлын ажилд томилогдсон тушаал шийдвэргүйгээр 8 дугаар сард цалин тооцож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"

5. Аймгийн аварга шалгаруулах волейболын тэмцээнд 60 литр түлшээр 180 км явсан боловч 30\*3990=119.7 мянган төгрөгийн түлшийг Hyundai Grace микро автобусанд түрээсийн хөлс өгсөн боловч жолоочтой гэрээ байгуулаагүй илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"

## **5.2 Албан шаардлага**

1. Байгууллагын эд хариуцагч Л.Жигмэддоржийг ажлаас чөлөөлж, Д.Ариунааг томилсон боловч байгууллагын эд хөрөнгийн тооллого хийж хүлээлцэх ажлыг зохион байгуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:", 12.2.2-д "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед;" МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.2-д заасны дагуу албан шаардлага өгөх.

2. Байгууллагын дарга 2022 оны 06 дугаар сарын 27-ний өдөр Б.Нэргүйбаатартай мэдээлэл дамжуулах цагаан хоолой хийхээр 2050.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулсан ч гэрээний дагуу ажил гүйцэтгээгүй зориулалт бус хөрөнгө бэлтгэж байгууллагын данс бүртгэлд орлого авсан ч анхан шатны баримтын бүрдэл хангаагүй нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны

баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно."

3. Хүүхдийн хоолны зардалд тендерт шалгаруулаагүй шууд худалдан авалт хийсэн нь Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан " Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,үйлчилгээ, худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ" -ийг баримтлаагүй, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.2 дахь заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй нь Шууд худалдан авалт хийж байгаа зөрчлийг таслан зогсоох, цаашид ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

4.Тайлант оны батлагдсан орон тоонд тусгагдаагүй манаач, сургуулийн эмчийн цалингийн зардалд нийт 1.5 сая төгрөгийг зарцуулсан. Санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалтын дагуу хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

### **5.3 Зөвлөмж**

#### **1.Худалдан авалттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: 1.1.Нягтлан бодогч Б.Батцэцэгтэй хамаарал бүхий этгээд Б.Бямбацогтоос 8957.0 мянган төгрөгийн хүнсний материал /мах/ худалдан авсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно"

Өгсөн зөвлөмж: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно"

#### **2.Дотоод хяналттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: 2.2.Өмч хамгаалах зөвлөл, байгууллагын дотоод хяналт нь тайлант онд байгууллагын үйл ажиллагаа, өмч хөрөнгөтэй холбоотой дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулаагүй. ЗГ-ын 2011 оны 311 тогтоолын дагуу дотоод хяналт шалгалт хийх төлөвлөгөөнд тусгасан ажил бүрээр удирдамж, төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй.

Өгсөн зөвлөмж: ЗГ-ын 2011 оны 311 тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам", Байгууллагын дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, төлөвлөгөөнд туссан ажил бүрээр удирдамж төлөвлөгөө боловсруулан ажиллаж, гарсан алдаа зөрчлийн биелэлтийг тооцдог байхаар зөвлөмж өгөх.

#### **3.Урамшуулалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: 3.1.Үр дүнгийн урамшуулал олгохдоо зарим албан хаагчийн ажил үүргийн гүйцэтгэлийн чанар, үр дүнг гүйцэтгэл, үр дүнг тооцоогүй олгосон нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам гишүүний баталсан журмыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэх

#### 4. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Багш, ажилчидтай Хөдөлмөрийн тухай хуулийн 43.2.2-д заасны дагуу ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй.

Өгсөн зөвлөмж: Багш, ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлэх.

#### 5. Ур чадварын нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: 5.1. Багш, зарим албан тушаалтан ажилчдад ур чадварын нэмэгдэл олгохдоо Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллыг сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"-ийг баримтлаагүй хавтгайруулан олгосон.

Өгсөн зөвлөмж: Багш, зарим албан тушаалтад ур чадварыг олгохдоо Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллыг сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"-ээр дүгнэж тооцон олгож байх зөвлөмж хүргүүлэх.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад **2023** оны **05** дугаар сарын **25**-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөрөнгө шилжүүлсэн	1	3,947.0			1	3,947.0	1	3,947.0				
Бичилт	1	237.8			1	237.8	1	237.8				
Шууд зардалд бичсэн	1	11,855.1			1	11,855.1	1	11,855.1				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>16,040</b>			<b>3</b>	<b>16,040</b>	<b>3</b>	<b>16,040</b>				

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Албан тушаалтны тоо			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бүрэгхангай сумын ЕБС	15	128,441.7	5	4,383.8	3	121,150	6	1,388.02	1	1519,9		
<b>Дүн</b>	<b>15</b>	<b>128,441.7</b>	<b>5</b>	<b>4,383.8</b>	<b>3</b>	<b>121,150</b>	<b>6</b>	<b>1,388.02</b>	<b>1</b>	<b>1519,9</b>		